

2007.10.30

Дугаар 144

Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх  
зохицуулалтын үйлчилгээний хөлсний  
хэмжээг тооцох аргачлалыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 122 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлал”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 33 дугаар тогтоолын “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журам”-ын 1.3 дахь хэсгээс “...банк бус санхүүгийн байгууллага” гэснийг, мөн журмын 1.4 дэх хэсгээс “...Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээг хавсралт 1-д” гэснийг тус тус хассугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, батлагдсан аргачлалыг нийтэд мэдээлж, мөрдүүлэн ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС  
ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүр төвлөрүүлэх болон тухай бүр нэг удаа төвлөрүүлэх гэж 2 ангилна.

1. Жил бүр төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг дараах байдлаар тооцно:

1.1. Банк бус санхүүгийн байгууллагуудын байршлаас хамаарч тогтоосон хөлсийг тогтмолоор төвлөрүүлнэ. Энэ хөлсний хэмжээг тухайн банк бус санхүүгийн байгууллага нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байгаа бол 500 000 төгрөг, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж байгаа бол 250 000 төгрөг, бусад аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бол 50 000 төгрөг байхаар тогтоосон.

1.2. Энэ аргачлалын 1.1-д дурдсанаас гадна банк бус санхүүгийн байгууллагаас эрхлэх банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлөөс хамаарч тогтоосон хөлсийг тогтмолоор төвлөрүүлнэ. Гэхдээ энэхүү хөлсийг дүрмийн сангийн хэмжээг 5 ангилалд хувааж тухайн ангилал тус бүрээс хамаарч ялгаатай тогтоосон болно.

2. Тухай бүр нэг удаа төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлс нь салбар, төлөөлөгчийн газраа нээх, компанийн оноосон нэрийг өөрчлөх, үрэгдүүлсэн, гэмтээсэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг солих, нөхөн олгоход гэсэн нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаанаас авах хөлс юм.

Банк бус санхүүгийн байгууллагын оноосон нэрийг Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тавьсан шаардлагын улмаас өөрчилж байгаа бол Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 122 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан хөлс болох 2 000 000 төгрөгийг төвлөрүүлэхгүй.

3. Улаанбаатар хотоос бусад аймагт үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллага салбараа Улаанбаатар хотод нээвэл уг банк бус санхүүгийн байгууллагын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллагын жишгээр тооцож авна.

Жишээ 1. “А” банк бус санхүүгийн байгууллага 200 000 000 төгрөгийн дүрмийн сантай бөгөөд Улаанбаатар хотод зээлийн болон гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулдаг. Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцож үзвэл дараах байдалтай байна.

500 000 төгрөг /Улаанбаатар хотод байрладаг болохын хувьд төлөх хөлс/ + 150 000 төгрөг /Зээлийн үйл ажиллагаа явуулдаг тул төлөх хөлс/ + 100 000 төгрөг /гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулдаг тул төлөх хөлс/ = 750 000 төгрөг /”А” ББСБ-аас жил бүр төвлөрүүлэх нийт хөлс/

“А” банк бус санхүүгийн байгууллага нь 200 000 000 төгрөгийн дүрмийн сантай тул дүрмийн сангийн хэмжээнээс хамаарч хуваасан 5 ангиллын 100 000 001 - 200 000 000 төгрөгийн ангилалд хамаарах тул зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн хөлсийг 150 000 төгрөг, гадаад валютын үйл ажиллагаа эрхэлж байгаагийн хөлсийг 100 000 төгрөгөөр тус тус тооцно.

Жишээ 2. “Б” банк бус санхүүгийн байгууллага 300 000 000 төгрөгийн дүрмийн сантай бөгөөд Хөвсгөл аймагт зээлийн үйл ажиллагаа явуулдаг. Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцож үзвэл дараах байдалтай байна.

50 000 төгрөг /Улаанбаатар хот, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Дархан-Уул аймгийн Дархан сумаас бусад аймагт байрладаг болохын хувьд төлөх хөлс/ + 300 000 төгрөг /Зээлийн үйл ажиллагаа явуулдаг тул төлөх хөлс/ = 350 000 төгрөг /”Б” ББСБ-аас жил бүр төвлөрүүлэх нийт хөлс/

“Б” банк бус санхүүгийн байгууллага нь 300 000 000 төгрөгийн дүрмийн сантай тул дүрмийн сангийн хэмжээнээс хамаарч хуваасан 5 ангиллын 200 000 001-400 000 000 төгрөгийн ангилалд хамаарах тул зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн хөлсийг 300 000 төгрөгөөр тооцно.

Жишээ 3. Хэрэв Жишээ 2-т дурдсан “Б” банк бус санхүүгийн байгууллага нь хотод өөрийн салбараа нээн ажиллуулбал банк бус санхүүгийн байгууллагын байршлаас хамаарч төвлөрүүлэх хөлсийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг банк бус санхүүгийн байгууллагынхтай адил буюу 500 000 төгрөгөөр тооцно.

Мөн үйл ажиллагааны төрлөөс хамаарч төвлөрүүлэх хөлсийг тооцохдоо дүрмийн сан нь 300 000 000 төгрөг учир ангиллын 200 000 001-400 000 000 төгрөгийн ангилалд хамаарах учир тэр жишгээр тооцно. Хэрэв дүрмийн сан нь 600 000 000 төгрөг гэж үзвэл 400 000 001 -800 000 000 төгрөгийн ангилалд хамаарах бөгөөд хөлсийг уг ангиллын жишгээр тооцно.